



**ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН  
ТУШААЛ**

2019 оны 12 сарын 20 өдөр

Дугаар A/73

Улаанбаатар хот

Г Журам батлах тухай Г

Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 24.5 дахь заалт, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 470 дугаар тушаал, Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын 2015 оны хамтарсан 97/56 тоот тушаал, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн Удирдлагын зөвлөлийн 2019 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зоонозын өвчин судлалын үндэсний төвөөс төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, эрүүл мэндийн бус байгууллага, тэдгээрийн ажилчдад зоонозын халдвараас сэргийлэх мэдлэг олгоход чиглэсэн сургалтын журмыг 1 дүгээр, сургалтад хамрагдсан мэргэжилтнүүдэд олгох гэрчилгээний загварыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Энэхүү журмыг төвийн бүх ажилчдад танилцуулж 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдлөг болгон ажиллахыг албадын дарга, тасгийн эрхлэгч нарт даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны албаны дарга /Ц.Энхбаярт/-д үүрэг болгосугай.



Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн ерөнхий  
захирлын 2019 оны 12 дугаар сарын 00 - ний  
өдрийн 11 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

TT35150 4999999

## ЗАХИАЛГАТ СУРГАЛТЫН ЖУРАМ

### НЭГ. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журам нь Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 24.5 дах заалт, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 470 дугаар тушаал, Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын хамтарсан 2015 оны 97/56 тоот тушаалболон бусад холбогдох хууль тогтоомжийн үндэслэлтэрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, эрүүл мэндийн бус байгууллага, тэдгээрийн ажилчдадзоонозын халдвараас сэргийлэх мэдлэг олгоход чиглэсэн сургалтын харилцааг зохицуулахад чиглэгдэнэ.
- 1.2 Энэхүү журмыг Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн хэмжээнд дагаж мөрдөнө.

### ХОЁР. Захиалгат сургалтыг зохион байгуулах зарчим, агуулга

- 2.1 Захиалгат сургалт нь зоонозын халдвараас сэргийлэх мэдлэг олгоход чиглэсэн тодорхой сэдэв, хөтөлбөрийн дагуу явагдана.
- 2.2 Сургалтыг орон нутагт, ажлын байран дээр болон Зоонозын өвчин судлалын үндэсний төв дээр тус тус зохион байгуулж болно.
- 2.3 Багц цагийн сургалтыг Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс баталсан сэдвийн дагуу зохион байгуулна.

### ГУРАВ. Захиалгат сургалтыг зохион байгуулахад тавигдах шаардлага

- 3.1 Захиалагч нь сургалтын агуулга, чиглэлээ тодорхой бичсэн хүсэлтээ Зоонозын өвчин судлалын үндэсний төвд албан бичгээр ирүүлнэ.
- 3.2 Хувь хүн, мэргэжилтэн дээр захиалга ирүүлэхгүй бөгөөд сургалт явуулах мэргэжилтийг төвийн Ерөнхий захирал, ерөнхий захирлын эзгүйд дэд захирал, харьяалах албаны дарга томилно.
- 3.3 Сургалтыг хөдөө орон нутаг, ажлын байран дээрээ авах тохиолдолд сургалт явуулах байр, тоног төхөөрөмж, сургалтынхэрэглэгдэхүүн, сургагч багшийн аюулгүй байдлыг хангасан албан ёсныийтийн тээвэр, унаагаар хангахыг захиалагч тал бүрэнхариуцна.
- 3.4 Захиалгат сургалт нь хоногийн амралтын өдрүүдэд зохион байгуулагдсан тохиолдолд сургалтын цагийг ажилласнаар тооцож нөхөн амрааж болно.

### ДӨРӨВ. Захиалгат сургалтын зохион байгуулалт

- 4.1 Захиалагч сургалтын сэдэв, оролцогчдын тоо, сургалт авах газрыг тодорхой зааж, сургалтын болон гэрчилгээний төлбөрийг Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 100900020021 тоот дансанд тушаасан баримтыг хавсаргасан албан тоотыг сургалт авах өдрөөс 7-гоос доошгүй хоногийн өмнө ирүүлнэ.
- 4.2 Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн сургалтын үйл ажиллагаа эрхэлсэн нэгж алба албан тоот ирснээс хойш ажлын 1-3 хоногт багтаан хариу шийдвэрийг гаргаж захиалагчид мэдэгдэнэ.
- 4.3 Захиалагчийн ирүүлсэн хүсэлт, агуулгын чиглэлд үндэслэн сургагч багш, сургалтын багийг томилно.
- 4.4 Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн захиалгат сургалтын үндсэн сэдэв, цагийн төлбөр нь хүснэгтэд зааснаар байна.

№	Сэдэв	Хугацаа	Төлбөр
1	Хамгаалах өмсгөл өмсөх, тайлах дараалал	1 цаг	40 000
2	Зоонозын шалтгаант халдвирууд /өвчлөл тус бүрийн үнэлгээ/	1 цаг	40 000
3	Тархвар судлалын холбогдол тогтоох	1 цаг	30 000
4	Шуурхай удирдлагын зохион байгуулалт	1 цаг	30 000
5	Зоонозын шалтгаант халдвартыг илрүүлэх лабораторийн шинжилгээний аргууд	1 цаг	40 000
6	Тэжээлт орчин, биоүйлдвэрлэл	1 цаг	30 000
7	Ариутгал халдвартгүйтгэл	1 цаг	30 000
8	Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн хариу арга хэмжээ	1 цаг	40 000
9	Хээрийн эмнэлэг дэлгэх	1 цаг	40 000

4.5 Сургалтын үндсэн сэдвээс гадна захиалагч талын хүсэлтийн дагуу гүйцэтгэгч тал захиалагчтай харилцан тохиролцож шинчилсэн сэдэв, хөтөлбөр гарган сургалт зохион байгуулж болно.

#### ТАВ. Санхүүгийн зохицуулалт

- 5.1 Захиалгат сургалтаар орсон орлогыг дараах жишгийг баримтлан зарцуулна. Үүнд:
  - 5.1.1 Багшийн ажлын хэлсөнд 45%,
  - 5.1.2 Сургалтын орчин нөхцөл, техник хэрэгсэл сайжруулах хуримтлалд 45%,
  - 5.1.3 Сургалтын зохион байгуулалтын зардалд 10%,
- 5.2 Сургалтад хамрагдсан мэргэжилтэнд гэрчилгээ олгож болох бөгөөд гэрчилгээний үнэ 5000 төгрөг байна.
  - 5.2.1 Гэрчилгээ нь А5 хэмжээнээс томгуй байна.
  - 5.2.2 Гэрчилгээний дугаарыг он/бүртгэлийн дугаарын дарааллаар дугаарлана.
  - 5.2.3 Бүртгэлийг сургалтын албаны мэргэжилтэн хариуцна.
  - 5.2.4 Захиалагч талын хүсэлтээр гэрчилгээнд захиалагч талын лого, тамга тэмдгийг оруулж болно.
  - 5.2.5 Захиалагч тал гэрчилгээ авах мэргэжилтнүүдийн мэдээллийг Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн сургалтын үйл ажиллагаа эрхэлсэн нэгжид ирүүлнэ.
- 5.3 Багц цагийн сургалтын санхүүгийн зарцуулалтыг Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын хамтарсан 2015 оны 97/56 тоот тушаалын дагуу зарцуулна.

#### ЗУРГАА. Хариуцлага

- 6.1 Сургагч багш нь сургалтыг чанартай үр дүнтэй зохион байгуулах ба эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг баримтлан ажиллана.
- 6.2 Энэхүү журмыг зөрчсөн ажилтанд байгууллагын дотоод журмын 10, 11 дэх бүлгийг үндэслэн хариуцлага тооцно.
- 6.3 Захиалагч талын хариуцлагагүй байдлаас үүссэн аливаа асуудлыг Зоонозын өвчин судлалын үндэсний төв хариуцахгүй.



Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн ерөнхий  
захирлын 2019 оны 12 дугаар сарын 20 - ний  
өдрийн 11:23 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

**ЗАХИАЛГАТ СУРГАЛТАД ХАМРАГДСАН МЭРГЭЖИЛТНҮҮДЭД  
ОЛГОХ ГЭРЧИЛГЭЭНИЙ ЗАГВАР**

Загвар 1.

ЗӨСҮТ лого

ГЭРЧИЛГЭЭ

№ .../...

Эрхэм хүндэт ..... овогтой ..... танд  
Зоонозын өвчин судлалын үндэсний төвөөс зохион байгуулсан.../сургалтын сэдэв/.....  
сургалтад бүрэн хамрагдсан тул ГЭРЧИЛГЭЭ олгов.

ЗӨСҮТ-ийн Ерөнхий захирал

/Гарын үсэг, тамга/

Огноо

Загвар 2.

ЗӨСҮТ лого

Захиалагч талын лого

ГЭРЧИЛГЭЭ

№ ...../....

Эрхэм хүндэт ..... овогтой ..... танд  
Зоонозын өвчин судлалын үндэсний төвөөс зохион байгуулсан...../сургалтын  
сэдэв/..... сургалтад бүрэн хамрагдсан тул ГЭРЧИЛГЭЭ олгов.

ЗӨСҮТ-ИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

ЗАХИАЛАГЧ ТАЛ /албан тушаал/

/Гарын үсэг, тамга/

/Гарын үсэг, тамга/

Огноо